

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

ЗАСГИЙН ГАЗРЫН ГИШҮҮДЭД

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн хуралдааны 36 дугаар тэмдэглэлд:

“17.5.Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний эхний хагас жилийн хэрэгжилтэд хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээний дүнгийн талаар Монгол Улсын сайд, Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны дарга Э.Одбаяр Засгийн газрын гишүүдэд танилцуулав.

Үүнтэй холбогдуулан дараах арга хэмжээг авч ажиллахыг Засгийн газрын холбогдох гишүүдэд үүрэг болгов:

1.Монгол Улсын төсөв батлагдсаны дараа улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тодотгол хийдэг байх эрх зүйн зохицуулалт бий болгох талаар судалж, холбогдох арга хэмжээ авч ажиллахыг Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Л.Гантөмөрт;

2.Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний бодлого, зорилтын хүрээнд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ, тэдгээрийн шалгуур үзүүлэлт, суурь түвшин, хүрэх түвшнийг нөхцөл байдлын дүн шинжилгээ, тухайн үйл ажиллагааны эрэмбэ дараалал, гүйцэтгэх үе шатанд тулгуурлан оновчтой, зөв тодорхойлон төлөвлөж байхыг Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Л.Гантөмөрт;

3.Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6.10.3-т заасны дагуу улсын төсөв нь Монгол Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн байх шаардлагыг хангуулж, санхүүжилтийг жил бүрийн улсын төсөвт тусгах арга хэмжээ авч, төсвийн гүйцэтгэлийг тайлагнаж ажиллахыг Сангийн сайд Б.Жавхланд;

4.Хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн явцад байнгын хяналт тавьж, хэрэгжилт удаашралтай, хангалтгүй арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар тодорхой арга хэмжээ авч, төлөвлөгөөний биелэлтийг бүрэн хангаж ажиллахыг Засгийн газрын гишүүдэд.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР